

# ПРАГА

MNG

*хотод бид гэртээ  
байна!*



Integrační  
centrum  
Praha

Прага хотод амьдардаг  
шилжин суурьшигч нарт  
зориулсан товхимол



Прага хотын Интеграцийн төвд, олон нийтийн ашгийн бус байгууллагад зохиогдож хэвлэгдэв.  
3 дугаар хэвлэл, 2014 оны 12 дугаар сар

Энэ товхимолын шинэчлэлт ба хэвлэл нь Прага нийслэл хотын төсвөөс санхүүжүүлэгдсэн.

Бүх заагдсан мэдээлэл, холбоо барих боломж ба хаягууд нь 2014 оны 11-р сарын 30-н хүртэл хүчинтэй байсан. Энэ огноогоос хойш өөрчлөлт гарсан байвал бид хариуцахгүй.



## ШИЛЖИН СУУРЬШИГЧДАД ЗОРИУЛСАН ЧУХАЛ МЭДЭЭЛЛҮҮД

[www.icpraha.com](http://www.icpraha.com)  
[www.imigracniportal.cz](http://www.imigracniportal.cz)  
[www.integracnicentra.cz](http://www.integracnicentra.cz)  
[www.domavcr.cz](http://www.domavcr.cz)  
[www.migraceonline.cz](http://www.migraceonline.cz)  
[www.cizinci.cz](http://www.cizinci.cz)  
[www.mezikulturndialog.cz](http://www.mezikulturndialog.cz)

Эрхэм хүндэт найз нар аа,

та одоо энэ мэдээллийн товхимолын гуравдахь хэвлэлийг гартаа барьж байна, энэ товхимол нь нийслэл Прага хотын нутаг дэвсгэрт амьдарч байгаа шилжин суурьшигч гадаадын иргэдэд зориулагдсан бөгөөд түүнээс гадна бас төрийн засаг захиргааны, орон нутгийн өөртөө засах захиргааны ба ашгийн бус байгууллагуудын шилжин суурьшигч /цагаачлагч/ нартай ажилладаг ажилтанд зориулагдсан юм.

Интеграцийн төв Прага, олон нийтийн ашгийн бус байгууллага, „Бүгдийн метрополи-нийслэл“ гэсэн уриан дор ажиллахдаа, манай гол зорилгуудын нэг болох - Прага нийслэл хотын нутаг дэвсгэрт амьдарч байгаа шилжин суурьшигч нар нь манай нийслэл хотын бүрэн эрхтэй иргэд болж байгаагаа ухамсарлан, олон нийтийн амьдралд хамтран оролцож байхын төлөө зохистой нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.

Энэ мэдээллийн товхимол нь тухайн байгууллага, албан газар ба тэдний үйлдвэрчний эвлэлүүдийн тухай үндсэн мэдээллийг шилжин суурьшигч нарт хамгийн сайнаар ойлгуулж өгөхийн тулд гарын авлага болгож зохиогдсон бөгөөд Чех улсын амьдралтай холбоотой өдөр тутмын асуудлыг шийдвэрлэхэд нь түшиг тулгуур болж байна.

Энэ товхимолын гол зорилго нь та нарт яахаа мэдэхгүй болсон үед чинь тус болох хувь хүн, албан байгууллагын тухай цаашдах мэдээллийг эсвэл интернэт хуудсан дахь холбоо барих хаягийг өгөх явдал юм.

Прага хот бол таны шинэ гэр, орон нутаг ба БҮГДИЙН метрополи болохыг бид бүгдээрээ хүсэж байна!

Интеграцийн төв Прага, олон нийтийн ашгийн бус байгууллагын ажилтнуудын баг.



## АГУУЛГА

Прага .....	4
Нийслэл хот Прага ба хотын хорооллууд .....	5
Интеграцийн төв Прага, олон нийтийн ашгийн бус байгууллага .....	8
ИТП бол ерөнхийдөө 6 холбоо барих газартай .....	10
БНЧУ-д оршин суух зөвшөөрөл .....	12
Нийгмийн хангамж .....	13
Гэр бүл ба хүүхэд .....	14
Боловсрол .....	15
Нострификаци .....	16
Чех хэлний курсууд .....	17
Эрүүл мэндийн даатгал .....	17
Хөдөлмөр эрхлэх нь .....	18
Хувиараа аж ахуй эрхлэх нь .....	19
Хямралын байдлыг яаж шийдвэрлэх вэ .....	19
Тээвэр .....	22
Соёл .....	23
Шилжин суурьшигч нартай ажилладаг ашгийн бус байгууллагуудын жагсаалт .....	24
Шилжин суурьшигч нарын байгууллагууд .....	26



# ПРАГА



Прага бол Чех улсын нийслэл ба хамгийн том хот болох бөгөөд Чехийн тэг дунд нь Влтава голын эргээр оршдог. Өнөөг хүртэл арван нэг зуун жилийн туршид хөгжиж ирсэн. Орчин цагийн байдлаар хотын нутаг дэвсгэрийн хэмжээ нь 496 хавтгай дөрвөлжин км ба ойролцоогоор 1 200 000 хүн амтай. 1920 оноос хойш „Нийслэл хот Прага“ гэдэг албан ёсны нэртэй болсон. „Прага – Европын зүрхэн“ гэсэн үг хэллэг нь Европын тэг тунд оршдог газар зүйн байршлыг нь зааж байна.

Прага хот байгуулагдсан тухай домгоос харж үзэхэд энэ хотын тухай Либуше хатны хэлсэн алдарт бошиглолын үг: „Би нэг том хот байхыг нь зөгнөн харж байна, түүний алдар цол нь од мичинд хүрэх болтугай. Эндээс хол, нэг бүтэн өдөр явж хүрэхэд, ой модны дотор нэг газарт ирэхэд, тэнд нэг эрэгтэй хүн модоор босго хийж байхыг харж болно. Энэ босго /чех хэлээр прах/ гэсэн үгээс энэ газрыг Прага гэж нэрлээрэй“.

Прага нь шинээр бий болж байсан Чех улсын төв удалгүй болсон. Прагын их шилтгээнээс төр баригч нар нь ойрхи газруудыг захирч эхлэсэн. Өнөөдөр ч гэсэн Прагын их шилтгээн дотор улсын тэргүүн – Чех улсын ерөнхийлөгч нь амьдарч ажлаа явуулдаг. Прагад байдаг Чех улсын засгийн газрын ордон нь улсын дээд гүйцэтгэх засаг захиргааны байгууллага юм. Хотын засаг захиргаа нь Прага нийслэл хотын нутаг дэвсгэрт албан ёсны хариуцлагатай, хотын захиргааны ба аймгийн засаг захиргааны үүргийг биелүүлдэг.

Түүхийн талаас хамгийн их ач холбогдолтой барилгууд нь Прага 1 гэдэг хотын хороололд байдаг, мөн дундад зууны үеийн хотын төв болно, энэ нь 1992 оноос хойш НҮБ-ийн дэлхийн соёлын дурсгалт газруудын жагсаалтанд бүртгэгдсэн. Энд Прага хотын жуулчдын бүх үзэх, харах ба бахархах зүйлүүд нь оршдог:

Прагын их шилтгээн нь Чехийн хамгийн их алдартай хэрэм болно. 9-р зуунаас эхлэж энд Чехийн тайж нар, хойшхи үед эзэн хаад нь байсан бөгөөд 1918 оноос хойш Чех улсын ерөнхийлөгчийн ордон болсон. Түүхэнд хоёр удаа Ариун Ромын их гүрний эзэн хааны суудаг өргөөний газар нь болсон. Гиннесийн амжилтын номд үүний тухай бичихдээ эртний хэрэмийн дотор хамгийн том нь байж магадгүй гэж тэмдэглэсэн юм.

Карлын гүүр бол Прага хотод байгаа Влтава гол дээгүүр гарах хамгийн эртний гүүр болох бөгөөд Чех улсад одоо хүртэл байгаа хамгийн эртний гүүрийн хоёрдахь нь болно. Карлын гүүр бол хотын хоёр хэсгийг, Хуучин хот ба Бага дүүргийг, холбодог бөгөөд энэ гүүр дээгүүр хаадын явдаг түүхэн зам гардаг.

Хуучин хотын талбай, урьд нь бас Их талбай, өнөөдөр хүмүүс түүнийг „Старомак“ гэж нэрлэдэг бөгөөд Прагын Хуучин хотын тэг дунд нь оршино. Энд бас хэд хэдэн түүхэн ач холбогдолтой барилганууд байдаг, жишээлвэл, Прагын цамхагийн одон орны цаг, Хуучин хотын засаг захиргааны байшин буюу Тынски сүм болно.

Прага хотын оршин тогтнолын үед энд дэлхий даяар алдартай хэд хэдэн хүмүүс амьдарч байсан. Хамгийн алдартай хүний дотор, жишээлвэл, Чехийн хаан ба эзэнт хаан IV Карел, хөгжмийн зохиолч Антонин Дворжак, дуурийн дуучин Эма Дестинова буюу уран зохиолчид Франц Кафка, Карел Чапек ба Ян Неруда болно. Хөгжмийн зохиолч Амадеус Моцарт бол Прага хотод богинохон хугацааны үед амьдарч байсан бөгөөд энд бүтээлээ туурвиж байсан юм.

# НИЙСЛЭЛ ХОТ ПРАГА БА ХОТЫН ХОРООЛЛУУД



## ПРАГА НИЙСЛЭЛ ХОТЫН ХОТЫН ЗАХИРГАА (ПНХХЗ)

Mariánské náměstí 2, 110 01 Praha 1

[www.praha.eu](http://www.praha.eu)

Прага нийслэл хотын Хотын засаг захиргаа нь олон нийтийн засаг захиргаа биелүүлэх үүрэгтэй, түүний үйл ажиллагаа нь юуны өмнө Прага нийслэл хотын иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдсэн. Прага нийслэл хотын засаг захиргааны ба аймгийн засаг захиргааны үйл ажиллагааг хариуцдаг.

## PRAŽSKÉ KONTAKTNÍ CENTRUM

+420 12 444

[info@praha.eu](mailto:info@praha.eu)

[www.praguewelcome.cz](http://www.praguewelcome.cz)

Прага нийслэл хотын хуваарилалт нь их нарийн төвөгтэй юм. Прага бол 57 биеэ даасан хотын хорооллуудтай гэж мэдэх нь танд ашиг тустай (цаашдаа зөвхөн хотын хорооллууд гэх). Энэ хорооллуудын дотор 22 биеэ даасан засах дүүрэгүүд бий, энэ дүүрэгүүд нь тус бүрдээ дүүргийн засаг захиргаатай юм.

Та оршин сууж байгаа байрны хаягийнхаа дагуу тодорхой дүүргийн захиргаанд харьяалагдах болно. Хотын дүүрэг болгоны захиргаанд харьяалагдах салбарууд байдаг (хувиараа аж ахуй эрхлэх бүртгэлийн алба, иргэдийн байдлыг бүртгэх газар, нийгмийн, боловсролын салбар гэх мэт).

### Praha 1

Vodičkova 681/18,  
115 68 Praha 1

+420 221 097 111

[posta@praha1.cz](mailto:posta@praha1.cz)

[www.praha1.cz](http://www.praha1.cz)

### Praha 2

Náměstí Míru 20/600,  
120 39 Praha 2

+420 236 044 111

[infocentrum@p2.mepnet.cz](mailto:infocentrum@p2.mepnet.cz)

[www.praha2.cz](http://www.praha2.cz)

### Praha 3

Havlíčkovo nám. 9/700,  
130 85 Praha 3

+420 222 116 111

[podatelna@praha3.cz](mailto:podatelna@praha3.cz)

[www.praha3.cz](http://www.praha3.cz)

### Praha 4

Antala Staška 2059/80b,  
140 46 Praha 4

+420 800 194 237

[radnice@praha4.cz](mailto:radnice@praha4.cz)

[www.praha4.cz](http://www.praha4.cz)

### Praha 5

Náměstí 14. října 1381/4,  
150 22 Praha 5

+420 800 800 005

[podatelna@praha5.cz](mailto:podatelna@praha5.cz)

[www.praha5.cz](http://www.praha5.cz)

### Praha 6

Československé  
armády 23/601,  
160 52 Praha 6

+420 800 800 001

[podatelna@praha6.cz](mailto:podatelna@praha6.cz)

[www.praha6.cz](http://www.praha6.cz)

<b>Praha 7</b>	nábř. Kpt. Jaroše 1000, 170 00 Praha 7	+420 220 141 111	podatelna@p7.mepnet.cz	www.praha7.cz
<b>Praha 8</b>	Zenklova 1/35, 180 48 Praha 8	+420 222 805 111	posta@praaha8.cz	www.praha8.cz
<b>Praha 9</b>	Sokolovská 14/324, 148 49 Praha 9	+420 283 091 111	podatelna@praaha9.cz	www.praha9.cz
<b>Praha 10</b>	Vršovická 68, 101 38 Praha 10	+420 840 111 213	posta@praaha10.cz	www.praha10.cz
<b>Praha 11</b>	Ocelíkova 672/1, 149 41 Praha 4	+420 800 104 300	podatelna@p11.mepnet.cz	www.praha11.cz
<b>Praha 12</b>	Písková 830/25, 143 00 Praha 4	+420 244 028 111	informace@p12.mepnet.cz	www.praha12.cz
<b>Praha 13</b>	Sluneční nám. 13/2580, 158 00 Praha 5	+420 800 130 000	dotazy@p13.mepnet.cz	www.praha13.cz
<b>Praha 14</b>	Bratří Venclíků 1073, 198 21 Praha 9	+420 281 005 111	informace@praaha14.cz	www.praha14.cz
<b>Praha 15</b>	Boloňská 478/1, 109 00 Praha 10	+420 281 003 111	podatelna@praaha15.cz	www.praha15.cz
<b>Praha 16</b>	Václava Balého 23/3, 153 00 Praha 5	+420 234 128 111	elpodatelna@praaha16.eu	www.mcpraha16.cz
<b>Praha 17</b>	Žalanského 291/12b, 163 00 Praha 6	+420 234 683 111	podatelna@repy.mepnet.cz	www.repy.cz
<b>Praha 18</b>	Bechyňská 639, 199 00 Praha 9	+420 284 028 111	podatelna@letnany.cz	www.praha18.cz
<b>Praha 19</b>	Semilská 43/1, 197 00 Praha 9	+420 284 080 811	info@kbely.mepnet.cz	www.praha19.cz
<b>Praha 20</b>	Jívanská 647, 193 21 Praha 9	+420 271 071 611	urad@pocernice.cz	www.pocernice.cz

<b>Praha 21</b>	Staroklánovická 260, 190 16 Praha 9	+420 281 012 911	podatelna@praaha21.cz	www.praha21.cz
<b>Praha 22</b>	Nové náměstí 1250, 104 00 Praha 114	+420 271 071 812	podatelna@praaha22.cz	www.praha22.cz

### САЛБАРУУД БУЮУ ХААНА ХЭН ЮУ ХИЙДЭГ ВЭ

Хотын дүүрэг болгоны засаг захиргааны газарт өөр өөр нэртэй салбарууд байж болно. Гэвч хотын дүүрэг болгонд нь танд хэрэгтэй салбарыг олж болно

 [www.portal.gov.cz](http://www.portal.gov.cz)

### ХОТЫН ДҮҮРГИЙН ҮНДСЭН САЛБАРУУД НЬ

▣ **ХУВИАРАА АЖ АХУЙ ЭРХЛЭХ БҮРТГЭЛИЙН АЛБА** (Živnostenský odbor) – хувиараа аж ахуй эрхлэгч ба үйлдвэрийн эздийн талаар хариуцдаг бөгөөд та нар энд хувиараа аж ахуй эрхлэх тухай бүртгэлээ хийлгэж болно.

▣ **ИРГЭДИЙН БАЙДЛЫГ БҮРТГЭХ ГАЗАР** (matrika) – иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх байгуулага юм. Энд гэр бүл болоход хэрэгтэй бичиг баримтыг бүртгэдэг – гэрлэлтийн гэрчилгээ, хүүхэд төрсний бичиг баримт – төрсний гэрчилгээ, нас барсны тухай бичиг баримт – нас барсны гэрчилгээ, ижил хүйстэн хамтран амьдрагчаа бүртгүүлэх, нэр/овгийн өөрчлөлт хийлгэх гэх мэт.

▣ **БАРИЛГЫН САЛБАР** (Stavební odbor) – газар нутаг дэвсгэрийн тухай шийдвэр гаргадаг, барилга байрлуулах тухай тодорхойлолт, барилга барих зөвшөөрлийн тухай бичиг баримт, барилгуудын бүртгэл хийдэг гэх мэт.

▣ **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САЛБАР /НИЙГМИЙН ХЭРГИЙН САЛБАР** (Sociální odbor/ odbor sociálních věcí) – ялангуяа нийгмийн халамж асаргаа ба урьдчилан сэргийлэхэд анхаарлаа тавьдаг – энэ салбар бол асуудалтай гэр бүлүүдэд хараа хяналт тавьдаг, хүүхэд ба залуучуудад мөн насанд хүрсэн хүмүүст харгалзагчийг тогтоодог, асрамжийн үйлчилгээтэй байранд буюу өндөр настны байрлах байранд оруулах өргөдлийг бүртгэдэг, нийгмийн ядуу иргэдийг орон сууцаар хангаж өгдөг, байнга оршин суух зөвшөөрөлтэй ба тахир дутуугийн тэтгэмж авдаг хүмүүст машин тавих картыг олгодог. Энэ салбарт олонтоо 1. Хүүхдийг хамгаалах нийгэм-хууль эрхийн байгууллага ( XXNHЭБ, OSPOD) хамт оршдог (14-р хуудас үзнэ үү).

▣ **БОЛОВСРОЛЫН САЛБАР** (Odbor školství) – жишээлвэл, хүүхдийг оршин суух хаягийн дагуу цэцэрлэгт/суурь боловсролын сургуульд бүртгэж өгдөг; сургуулийн байгууллагыг бий болгож, шалгаж бас цуцалдаг, сургуулийн боловсролын төсөв, төлөвлөгөөг зохицуулдаг, ингэснээр хүүхэд, сурагчид, оюутнуудын сургалтыг хангаж чанарыг дээшлүүлдэг.

▣ **ТЭЭВРИЙН САЛБАР** (Odbor dopravy) – жолоочийн үнэмлэх ба жолоодох эрх олгох/ өөрчлөх, тээврийн хэрэгслийг бүртгэдэг гэх мэт.

 **Чех ПОИНТ**

Чех ПОИНТ бол олон нийтийн засаг захиргааны ажилд туслах үүрэгтэй газар болно, нэг дороос улсын албан байгууллагатай харьцах үйл ажиллагааг өргөжүүлэх боломжтой болсон.

### Энд үзүүлэх үйлчилгээнүүд танд ашиг тустай:


▣ үл хөдлөх хөрөнгийн кадастраас, худалдааны бүртгэлээс, хувиараа аж ахуй эрхлэх бүртгэлээс, ял шийтгэлгүйн (хуулийн этгээдэд ч гэсэн) буюу жолоочийн оноогийн үнэлэлтээс гэрчилгээ олгож болно гэх мэт.

## Чех ПОИНТ

Чех ПОИНТ бол олон нийтийн засаг захиргааны ажилд туслах үүрэгтэй газар болно, Чех ПОИНТУУД нь хотын зарим дүүргийн засаг захиргааны газарт байдаг, Чех шууданд ба зарим нотариатчийн газарт ч гэсэн байдаг.

 [www.czechpoint.cz/web](http://www.czechpoint.cz/web)

Чех ПОИНТЫН холбоо барих газарт олдсон гэрчилгээнүүд нь гол төлөв Чех улсын нутаг дэвсгэрт ашиглахад нь зориулагдсан байдаг!



## ИНТЕГРАЦИЙН ТӨВ ПРАГА, ОЛОН НИЙТИЙН АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Интеграцийн төв Прага, олон нийтийн ашгийн бус байгууллага (цаашдаа гагцхүү ИТП) нь Прага нийслэл хотын Зөвлөлийн тогтоолыг үндэслэж байгуулагдаж дараа нь 2012 оны 3-р сарын 14-нд Прага нийслэл хотын Хотын захиргаагаар дэмжин батлагдсан юм.

Чех улсын аймаг тус бүрт ажиллаж байгаа 13 интеграцийн төвүүдийн дотор Прагын Интеграцийн төв нь 11 дэхь нь болж байгуулагдсан.

ИТП нь Прага нийслэл хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд түнш ашгийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, гуравдагч орнуудаас ирсэн шилжин суурьшигч гадаадын иргэдэд тусламж үзүүлдэг байгууллага юм.

### ИТП-ЫН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

■ **НИЙГМИЙН ЗӨВЛӨЛГӨӨ** – улсын нийгмийн дэмжлэг буюу нийгмийн асрамжийн тэтгэмж олгоход туслах ба гачигдалд туслалцаа үзүүлэх; БНЧУ-ын нийгмийн системтэй танилцах; ажил хайх ба БНЧУ-д хөдөлмөр эрхлэх асуудлыг шийдвэрлэхэд тусламж үзүүлэх; тохиромжтой байр хайх; эрүүл мэндийн даатгалд болон тусламжинд хамрагдахад нь туслах; боловсролын асуудлаар туслах (хүүхдийг цэцэрлэгт бүртгэх, нострификаци хийлгэх) гэх мэт.

■ **ХУУЛЬ ЭРХИЙН ЗӨВЛӨЛГӨӨ** – Чех улсын хууль эрхийн системийн тухай мэдээлэл, Чех улсад оршин суух тухай өргөдөл гаргах буюу сунгахад нь туслах; иргэний хууль эрхийн үйл ажиллагаа явуулахад туслах (салалт, ажил олгогч нь ажилтанд цалин төлөөгүй тохиолдолд); эрхзүйн асуудлаар зөвлөлгөө өгөх; тус улсын иргэншил хүсэхэд шаардлагатай мэдээлэл өгөх гэх мэт.

■ **АЛБАН ГАЗАРТ ДАГАЛДАН ОЧИЖ ҮЙЛЧЛЭХ** – албан байгууллагатай холбоо барихад туслах, хэлэлцээ хийхэд орчуулга хийх ба туслалцах

■ **ЧЕХ ХЭЛНИЙ КУРСУУД** – эхлэн суралцагчдын хичээл, бага зэрэг ахисан ба ахисан суралцагсдад зориулсан, дүрмийн болон ярианы хичээлүүд орно. А1 түвшний чех хэлний шалгалтанд бэлтгэнэ, энэ шалгалт амжилттай өгөх нь БНЧУ-д байнга оршин суух зөвшөөрөл олгох нөхцлийн нэг болдог. Энэ курсууд нь өглөөний, үдээс өмнөх ба үдээс хойших мөн оройн цагаар явагддаг, хэрвээ хэрэгцээтэй байвал, таны хүүхдийг сургалтын үеэр харгалзаж болно.

■ **НИЙГЭМ, СОЁЛЫН ЧИГЛЭЛИЙН КУРСУУД** – мэргэжилтний лекц унших хэлбэрээр явагдана, энд Чех улсын түүхийн тухай, чех ардын ёс заншил ба уламжлалын тухай, Чех

улсад оршин суух тухай, Чех улсын эрүүл мэндийн, нийгмийн буюу боловсролын системийн тухай, орлогын албан татварын мэдүүлэг өгөх тухай зэрэг мэдээлэл авч болно.

■ **СОЁЛЫН БА ХАМТРАН ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА** – ИТП нь жил бүр Прага хот даяар хэд хэдэн соёлын ба хамтын харилцааны үйл ажиллагаа явуулдаг, үүний гол зорилго нь Чех хүнийг шилжин суурьшигч нартай ойртуулж, тэдэнтэй найрсагаар хамтран амьдрахыг дэмжих.

■ **МЭДЭЭЛЛИЙН БОЛОМЖ** – үнэ төлбөргүйгээр интернет ашиглах; гадаад хэлээр хэвлэгдсэн мэргэжлийн, уран зохиолын, шүлэг, үргэлжилсэн өгүүлэгийн номууд, гадаад хэл дээрх сэтгүүлүүд бүхий номын сантай ба зурагт үзэх боломжтой

■ **МЭРГЭЖИЛТНИЙГ БОЛОВСРУУЛАХ** – улсын захиргааны ажилтан ба хувийн байгууллагын ажилтнууд, эмч нар, багш нар, хотын цагдаагийн байгууллагын ажилтнуудад зориулж мэргэжлийн сургалт, семинар явуулах гэх мэт. Зорилго нь эдгээр ажилтнуудыг асуудал бүхий шилжин суурьшигч нартай, шилжин суурьшигч нарыг Чехийн нийгэмтэй танилцуулах юм. Семинарууд нь цаашлаад олон соёлын хоорондох харилцаа тогтоохын үндэс болох энхүү харилцааг эзэмшихэд чиглэнэ.

■ **ЧӨЛӨӨТ ЦАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА** – ИТП-д байгаа өрөө танхимыг чөлөөт цагийн үйл ажиллагаанд тухайлбал дугуйлан, уулзалт, шилжин суурьшигч нарын үзэсгэлэн гаргах зэргээр зохиогдох үйл ажиллагаанд хэрэглэж болно гэх мэт.

### ИТП-ЫН ЗОРИЛГУУД

ИТП нь шилжин суурьшигч нарыг чехийн нийгэмд амархан дасан зохицолцоход нь туслах үйлчилгээнүүдийг санал болгож байна. ИТП-ын зорилго бол шилжин суурьшигч нарыг нийслэл Прага хотын төдийгүй Чех улсын бүрэн эрхт иргэн болж байхыг хүсч, үүнд улсын бүх байгууллагууд ба төрийн бус байгууллагууд нь хамтран оролцож хувь нэмэр оруулах юм.

### ИТП-ЫН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД ЯМАР ҮНЭТЭЙ ВЭ?


ИТП-ын бүх үйлчилгээнүүд нь Европын сангуудаас ба Прага нийслэл хотын төсвөөс санхүүжүүлэгдэж байгаа учраас ИТП-ын захиалагчдад ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР үйлчилнэ.

Үнэ төлбөргүй бол муу гэсэн үг биш! Харин ч эсрэгээр!

### ИТП-Д ТА ӨӨРИЙНХӨӨ ЭХ ХЭЛЭЭР ХАРИЛЦАЖ БОЛНО!

Хэрвээ та чех хэлээр ярьдаггүй бол, ИТП-тай холбоо барихдаа битгий айгаарай – ИТП-ын бүх ажилтнууд хэд хэдэн гадаад хэлээр ярилцдаг бөгөөд, хэрвээ таны хэлээр ярилцаж чадахгүй бол, бид танд орчуулагчийг олж өгнө.

### ТӨСЛИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД





# ИТП БОЛ ЕРӨНХИЙДӨӨ 6 ХОЛБОО БАРИХ ГАЗАРТАЙ


ИТП бол ерөнхийдөө 6 холбоо барих газартай – ИТП-ын Харилцах ба мэдээллийн төв нь Житна 1574/51-д байдаг, тэнд үнэ төлбөргүй интернет хэрэглэж болно, тэнд гадаад хэлээр хэвлэгдсэн номын сан, уулзалтын өрөө ба хүүхдийн булантай холбогдсон 2 том сургалтын танхим байдаг.

ИТП-ын бусад салбаруудад бас долоо хоногт хэд хэдэн өдөрт нийгмийн ба хууль эрхийн зөвлөлгөө өгдөг. Прага хотын хамтын ажиллагаа явуулж буй дүүргүүдэд байрладаг. Үүнд: Прага 4 – Панкрац, Прага 12 – Модржаны ба Либуш, Прага 12 – Стодулки ба Прага 14 – Черны Мост болно. Цаашид нь бас Прага 4 – Либуш хороололд байгаа вьетнамчуудын САПА зах дээрх товчоонд бидэнтэй холбоо барьж болно.

 [www.icpraha.com](http://www.icpraha.com)  
+420 252 543 846  
info@icpraha.com

## НИЙГМИЙН СҮЛЖЭЭНҮҮД

 /ICPraha  
 @ICPraha  
 /ICPraha



# БНЧУ-Д ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ

БНЧУ-д оршин суух зөвшөөрөл олгох тухай асуудлыг Дотоод явдлын яамны 2 хэлтэс хариуцдаг. Энэ бол гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар ба Цагаачлал ба шилжин суурьших бодлогын хэлтэс болно.

## ГАДААДЫН ИРГЭДИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ЦАГДААГИЙН ГАЗАР

Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар бол 90 хоног хүртэл богино хугацааны виз олгох зөвшөөрөл гаргадаг, Чех улсад шинээр ирсэн шилжин суурьшигч гадаадын иргэдийг бүртгэдэг, оршин суух зөвшөөрлийг шалгадаг (жишээлвэл, ажлын газарт, гудамжинд) ба Чех улсад оршин суух нөхцлийг зөрчсөн байвал тодорхой арга хэмжээ авдаг.

## ODDĚLENÍ POBYTOVÝCH AGEND

Olšanská 2, 130 51 Praha 3	+420 974 820 317 krpa.ocp.opa.podatelna@pcr.cz	Po, St: 08.00 – 17.00 Út, Čt: 08.00 – 15.00 Pá: 08.00 – 12.00
-------------------------------	---	---

## ЦАГААЧЛАЛ БА ШИЛЖИН СУУРЬШИХ БОДЛОГЫН ХЭЛТЭС (ЦШСБХ)

Цагаачлал ба шилжин суурьших бодлогын хэлтэс нь удаан хугацааны визний асуудлыг шийдвэрлэдэг, удаан хугацааны ба байнга оршин суух зөвшөөрөл, ЕХ иргэд ба тэдний гэр бүлийн гишүүдийн түр зуурын оршин суух, биометрийн өгөгдөлтэй үнэмлэх олгох гэм мэт асуудлыг шийдвэрлэдэг. Та байрны, нэр овгийн, хувь хүний байдлын, гадаад паспортын ба БНЧУ-д оршин суух зөвшөөрөл олгосон бичиг баримтанд гарсан бүх өөрчлөлтийг энэ хэлтэст мэдүүлэх үүрэгтэй.

## TRVALÉ POBYTU

Oddělení pobytu cizinců Praha I

Působnost: hl. m. Praha a okresy Praha-západ a Praha-východ

Nad Vršovskou horou 88/4 101 00 Praha 10	Po, St: 8.00 – 17.00; Út, Čt: 8.00 – 15.00 Pá: 8.00 – 11.00* *v pátek pouze pro objednané klienty
---	---

Хэрвээ та энэ хэлтэст очих хэрэг гарвал, уулзалтын цагаа урьдчилан утсаар тохирч болно. Тэгвэл та тэнд урт очер удаан хүлээхгүй болно! Захиалга өгөх утас: +420 974 820 680, ажиллах цаг : Даваа – Пүрэв 8.00 -16.00, Баасан 8.00 – 14:00.

Хэрвээ та байраа соливол, 30 хоногийн дотор мэдүүлэх ёстой, бусад өөрчлөлтийг өөрчлөлт гарснаас хойш хамгийн ихдээ 3 хоногийн дотор мэдүүлэх ёстой. Та нар тогтоосон хугацааг ямагт баримтлах хэрэгтэй!

## DLOUHODOVÉ A PŘECHODNÉ POBYTU

Oddělení pobytu cizinců Praha II, Působnost: okres Praha-západ

Zborovská 1505/13 150 00 Praha 5	Po, St: 8.00 – 17.00; Út, Čt: 8.00 – 15.00 Pá: 8.00 – 11.00*
-------------------------------------	---

Oddělení pobytu cizinců Praha III, Působnost: Praha 2, 4, 5 a 10

Cigánkova 1861/2 148 00 Praha 4	Po, St: 8.00 – 17.00; Út, Čt: 8.00 – 15.00 Pá: 8.00 – 12.00*
------------------------------------	---

Oddělení pobytu cizinců Praha IV, Působnost: Praha 1, 3, 6, 7, 8 a 9

Koněvova 188/32 130 00 Praha 3	Po, St: 8.00 – 17.00; Út, Čt: 8.00 – 15.00 Pá: 8.00 – 12.00*
-----------------------------------	---

Oddělení pobytu cizinců Praha V, Působnost: okres Praha-východ

Nad Štolou 936/3 170 34 Praha 7	Po, St: 8.00 – 15.00; Út, Čt: 8.00 – 16.00 Pá: 8.00 – 11.00*
------------------------------------	---

\*v pátek pouze pro objednané klienty

[www.imigracniportal.cz](http://www.imigracniportal.cz)

## ЧЕХ УЛСЫН ДОТООД ЯВДЛЫН ЯАМНЫ МЭДЭЭЛЛИЙН УТАС

БНЧУ-ын Дотоод явдлын яаманд оршин суух зөвшөөрөл олгох тухай хууль эрхийн асуудлаар утсаар утасдаж мэдээлэл авч болно. Энэ мэдээллийн утас нь гагцхүү чех ба англи хэлээр ажилладаг.

[pobyty@mvcv.cz](mailto:pobyty@mvcv.cz), +420 974 832 421, +420 974 832 418  
Утасны ажиллах цаг: даваа – баасан, 8.00–15.00

## НИЙГМИЙН ХАНГАМЖ

Чех улсад эдийн засгийн хувьд идэвхтэй ажиллаж байгаа иргэд нь нийгмийн хангамжийн системд татвараа төлдөг, энэ сангаас нийгмийн ядуу гачигдалтай хүмүүст, хүүхэдтэй гэр бүлүүдэд ба бусад бүлгүүдэд тусламж үзүүлдэг. Энэ нийгмийн хангамжийн системийн үйл ажиллагаа нь их нарийн төвөгтэй бөгөөд 3 үндсэн зүйл ба хэд хэдэн нийгмийн тэтгэмж ба тусламж болж хуваарилагддаг.

Бид танд энэ системийн үйл ажиллагааны тухай товчхон тойм дуртгаж байна:

### 1.) НИЙГМИЙН ДААТГАЛ

– өвчний даатгал, тэтгэврийн даатгал

Сумын нийгмийн хангамжийн захиргаа (CHX3) (OSZZ)

[www.cssz.cz/cz/kontakt/krajiska-a-okresni-pracoviste/praha/](http://www.cssz.cz/cz/kontakt/krajiska-a-okresni-pracoviste/praha/)

### 2.) УЛСЫН НИЙГМИЙН ТУСЛАМЖ (SSP)

– Хоёр төрлийн тэтгэмж олгодог, таны хувь хүний орлогын төвшингөөс хамаарч буюу үл хамааран олгогдоно.

а) Таны орлогын төвшингөөс хамаарч олгогдоно

– хүүхдийн тэтгэмж, орон сууцны тэтгэмж, амаржсаны тэтгэмж

б) Орлогын төвшингөөс үл хамааран олгогдоно – эцэг эхийн тэтгэмж, өргөмөл хүүхдийн тэтгэмж, оршуулгын тэтгэмж

[www.mpsv.cz/cs/2](http://www.mpsv.cz/cs/2)

### 3.) ГАЧИГДАЛД ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

– амин зуулгын тэтгэмж, байрны зардлын тусламж, онцгой байдал яаралтай тусламж

[www.mpsv.cz/cs/5](http://www.mpsv.cz/cs/5)

Хэрвээ та ямар нэг тэтгэмж авч болох тухай мэдээлэл олохыг хүсвэл, ИТП-ын нийгмийн зөвлөлгөө өгөх салбарт нь буюу бусад байгууллагад хандаж, захиалга өгөөд, тэр газарт очиж уулзаж болно (.24-р хуудас). Бид та нарыг дагуулан тэр байгууллагад очиж болно.

Bublina: Улсын нийгмийн тэтгэмж ба Гачигдалд тусалцаа үзүүлэх тухай өргөдлийг хөдөлмөрийн товчооны холбогдох хэсэгт өгдөг ( 18-р хуудас)

# ГЭР БҮЛ БА ХҮҮХЭД

Чех улс бол гэр бүлийн талаар явуулах бодлогод идэвхтэй анхаарлаа тавьдаг бөгөөд хүүхэдтэй гэр бүлд дэмжлэг үзүүлдэг юм.

1.) Гэр бүлийн гишүүн бүрд буюу гэр бүлд нийтэд нь дэмжлэг үзүүлэхэд зориулсан, хэрвээ нийгмийн таатай бус байдалд орсон бол, нийгмээс тасарч хоцрогдохоос нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах зорилготой. Нийгмийн үйлчилгээ нь дараах зүйлээс бүрддэг: нийгмийн зөвлөлгөө, нийгмийн асрамжийн үйлчилгээ ба нийгмийн талаас урьдчилан сэргийлэх үйлчилгээ болно.

2.) Хүчинтэй байгаа гэр бүлийг дэмжих үйлчилгээнүүд, энэ нь урьдчилан сэргийлэх ба туслалцах үүрэгтэй. Гол зорилго нь найз нарын ба эхнэр нөхрийн, эцэг эхийн хоорондох хамтын амьдралыг тайвшруулах ба бэхжүүлэхэд зориулсан, гэр бүлийг хүүхдээ асрахад нь ажил болон гэр бүлийн хоорондох харьцааг зохицуулахад зориулагдсан юм. Энэ үйлчилгээнд дараах зүйлүүд хамаардаг: хүүхдийг асрах хувийн төвүүд, хүүхэд саатуулах хувийн газрууд; хүүхдүүдэд зориулсан чөлөөт цагийн ба боловсрох үйл ажиллагаанууд (жишээлвэл, чөлөөт цагийн спортын /дүрслэх урлагийн/хөгжмийн дугуйлангууд), эхчүүдийн төвүүд гэх мэт.

**i** Хүүхэд ба залуучуудын байранд хүүхэд ба залуучуудад зориулсан чөлөөт цагийн үйл ажиллагаануудыг санал болгодог.  
<http://skoly.praha-mesto.cz/parent9429/Urad/Kontakty/Mestske-organizace/area4464>

3.) 1. Хүүхдийг хамгаалах нийгэм-хууль эрхийн байгууллага ( XXNHЭБ, OSPOD) – энэ салбар нь хотын дүүргийн захиргааны нийгмийн салбарын харьяанд хамаардаг. Насанд хүрээгүй хүүхдийн тухай асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд хүүхдийн сонирхлыг харгалзан, тэднийг төлөөлдөг (жишээлвэл, хүүхдийн хүмүүжил нь хэнд даалгагдах вэ, хүүхдийн тэжээлийн төлбөр нь ямар хэмжээтэй байх вэ, хүүхэд ба эцэг эхийн харилцааг яаж зохицуулах вэ гэх мэт асуудал шийдвэрлэдэг).

## АЮУЛГҮЙН ШУГАМ

Хүүхдүүд ба залуучуудад (26 нас хүртэл) зориулсан аюулгүйн дугаараар үнэ төлбөргүй утасдаж аюулын үед тусламж авч болно. Энэ утас бүтэн жилийн турш өдөр бүр 24 цагийн дотор ажиллаж байдаг. Амьдралын хүнд түгшүүртэй байдалд орж, өөрийнхөө хүчээр дийлж чадахгүй буюу шийдэж чадахгүй үед нь энэ дугаараар утасдахад хүүхэд ба залуучуудад зөвлөлгөө ба тусламж үзүүлдэг.

**i** +420 116 111

## ЭЦЭГ ЭХИЙН ДУГААР

нь ялангуяа эцэг эхэд нь, өвөө эмээд нь ба бүх Чех улсад байгаа гэр бүлийн бусад гишүүнд аюулын үед утасдахад утсаар зөвлөлгөө ба тусламж үзүүлдэг.

**i** +420 840 111 234; [pomoc@rodicovskalinka.cz](mailto:pomoc@rodicovskalinka.cz)

## ЭХНЭР НӨХӨР БА ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ЗӨВЛӨЛГӨӨ ӨГӨХ ГАЗАР

Хэрвээ хамтран амьдрагчид, эхнэр нөхрийн буюу гэр бүлийн гишүүдийн хооронд төвөгтэй асуудлууд гарвал, энэ зөвлөлгөө өгөх газарт хандаж болно, салалтын буюу салалтын дараах асуудлаар, бас бусад харилцааны буюу хувь хүний хүнд хэцүү байдалд орвол, энд ирж зөвлөлгөө авч болно.

**i** [www.psychportal.cz/manzelske-rodinne-poradny](http://www.psychportal.cz/manzelske-rodinne-poradny)


## ЗАЛУУЧУУДЫН НАМ БОСГОТ КЛУБУУД (ЗНБК ) (NZDM)

„Нам босгот“ гэдэг ямар утгатай вэ? Энэ төрлийн клубт ямар ч хүүхэд/насанд хүрээгүй хүн ирж, энэ клубын үйлчилгээнд хамрагдаж болно, энэ үйлчилгээнүүд нь үнэ төлбөргүй байдаг. Нам босгот клубт чөлөөт цагийн үйлчилгээ явуулдаг (ууланд авирч гарах хана, дүрслэх урлагийн дугуйлан, ширээний хөл бөмбөг, хөгжим сонсох, нэмэлт сургалт гэх мэт) ба зөвлөгөө өгөх ба урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг (тамхи татахаас, мансууруулах бодисыг буруу ашиглахаас, шоолох доромжлохоос сэргийлэх гэх мэт). Хүүхэд энэ нам босгот клубт явахдаа чөлөөт цагаа илүү ашиг тустайгаар, аюулгүй орчин тойронд өнгөрөөж болно.

**i** [www.streetwork.cz](http://www.streetwork.cz)

## БОЛОВСРОЛ

Чех Улс бол бүх түвшиндээ их чанар сайтай боловсролын системтэй:



Чехийн сургуулиуд бол улсын (сургалт нь төлбөргүй) буюу хувийн (сургалт нь төлбөртэй, төлбөрийн хэмжээг сургууль нь тодорхойлдог.) гэж хуваадаг.

## ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ


■ Хүүхдийн цэцэрлэгт хүүхдээ бүртгүүлэх ёстой – жил болгон тогтмол 3-р сард хүүхдийг хүүхдийн цэцэрлэгт бүртгэдэг.

■ Таны хүүхэд сургуульд орохоос өмнөх жилдээ заавал хүүхдийн цэцэрлэгт явах хэрэгтэй гэж зөвлөлгөө өгч байна, ийм учраас энэ сургуульд орохын өмнөх жил нь үнэ төлбөргүй байдаг бөгөөд ийм хүүхдийг хүүхдийн цэцэрлэг нэн түрүүн авах ёстой.

■ Жил болгон 1-р сарын 15-аас 2-р сарын 15-нд хүртэл сургуульд орох хүүхдийг бүртгэдэг.

■ Дунд сургуульд сурах бол сургуулиас тогтоосон элсэлтийн шалгалт өгснийг үндэслэж

Чех улсад хүүхдийн цэцэрлэгт сул орон тооны хэмжээ нь хүрэлцээ багатай байдаг, тийм учраас таны сонгож олсон хүүхдийн цэцэрлэгт таны хүүхдийг авахгүй ч байж болно!



Хэрвээ та хүүхдээ зохих ёсоор нь асрахгүй ба хүүхдээ сургуульд нь явуулахгүй бол энэ байгууллага нь таны хүүхдийг танаас хураан авч болно.



